

# УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 01

Орхон аймаг

Тус тайлан нь төвийн албан хаагчдын ёс зүйн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг хэрхэн дагаж мөрдөх ёстой талаар хууль эрх зүйн ойлголт, мэдээлэл өгөх, олон нийтэд ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлаа тайлагнах зорилготой юм.

## 1. ТӨЛӨВЛӨГӨӨ

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дэргэдэх “Ёс зүйн дэд хороо” 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөө боловсруулан төвийн даргаар батлуулж, төлөвлөгөөг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах ажилтан
2025.01.10			
Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ			
Ёс зүйн дэд хорооны үйлдвэрлэвэр зохион байгуулалт, төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэмжээг салгуулах ажлын хүрээнд			
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ажиллах журмыг хэрэгжүүлж ажиллах	Жилийн турш	Бүх гишүүд
2	Хуралдааны батлал хангах, тэмдэглэл хөтлөх, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод ажлын зохион байгуулалт хангах	Тухай бүр	Д.Оюунбат
3	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөнд гишүүдээс санал авах, батлуулах	Тухай бүр	Д.Оюунбат
4	Гомдол, мэдээллийн хяналт шалгалтын материалыг хавтас үүсгэн хувийн хэрэгт хавсаргах, цахим мэдээллийн сан үүсгэх	Тухай бүр	Д.Оюунбат
5	Санхүүгийн төлөвлөлт хийж төвийн даргад тавигдуулах	2 сард	Бүх гишүүд
6	Гишүүдийн гомдол, мэдээлэлд хяналт шалгалт хийж ажилд шаардлагатай материалыг холбогдох албан тушаалтаас авах хүсэлт гаргах, дэмжлэг үзүүлэх	Тухай бүр	Бүх гишүүд
8	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн баталгааг хангуулах	Жилийн турш	Бүх гишүүд
Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, харууцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбоотой ажлын хүрээнд			
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хангах ажиллах	Жилийн турш	Бүх гишүүд
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар сургалт зохион байгуулах	6 сард	Бүх гишүүд
3	Байгууллагад шинээр ажилд орж буй ажилтанд ёс зүйн талаарх ойлголтыг өгч, танилцуулах	Тухай бүр	Бүх гишүүд

4	Иргэдээс болон төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгах, мэдээллийг хянан шийдвэрлэх, дүгнэлт гаргах	Тухай бүр	Д.Оюунбат
5	Дэд хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоох	Тухай бүр	Бүх гишүүд
6	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг УЛД/ОШТ-ийн дарга, оршлогчдад хүргүүлэх	Тухай бүр	Д.Оюунбат

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Д.Оюунбат* Д.ОЮУНБАТ  
ХЯНАСАН:  
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА *ОХ* ОХАНДМАА

## 2. СУРГАЛТ

### “ШИЛЖИЛТҮҮД” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА


Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хамт олон 2025.01.15-нд “Шилжилтүүд” сэдэвт сургалтад хамрагдлаа.

Сургалтыг Нийгмийн ажилтан, Боловсрол судлалын магистр Т.Мөнхцэцэг удирдаж, хүний амьдралын 0-60 хүртэлх насны үечлэл, энэ хооронд ямар ямар шилжилтүүд хийгддэг, хэрхэн даван туулах ёстой, юун дээр анхаарах хэрэгтэй талаар тайлбарлав. Улмаар албан хаагчид нас насны ялгаанаас хамаарч ямар зан байдалтай байдаг талаар ойлголт авч, харилцан ойлголцох боломжийг бүрдүүлсэн.

Түүнчлэн сэтгэл зүйн бяцхан оношилгоо явуулж, хариу тус бүрийг тайлбарлан, онцлог шинжүүдийн талаар ярилцсан юм. Хамт олон нэгнээ ойлгож, байгаагаар нь хүлээн авах нь хамтран ажиллахад дотно мэдрэмж бий болгон, ажлын бүтээмж дээшилдэг аж.

Мөн сургалтын дундуур хамт олны уур амьсгалыг сэргээх дасгал ажиллуулж, албан хаагчид хоорондоо сэтгэлийн үгээ илэрхийлэх боломж олгосон юм.

Эцэст нь, Мишээх төдийд тархи хууртаж аз жаргалын гормон ялгаруулдаг тул эерэг байж нүүр дүүрэн инээмсэглэн, гэр бүл, хамт олон, нийгэмдээ гэрэл сацруулахыг уриалав.



### ДУТАГДЛЫН ХАЖУУГААР ДУУГАЙ ӨНГӨРӨХ НЬ ГЭМТ ХЭРЭГ

Орхон аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв “Насан туршийн суралцахуйн төв” -тэй хамтран албан хаагчдын харилцааны ёс зүйд чиглэсэн сургалтыг 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр зохион байгууллаа.



Албан хаагчид тус сургалтаар харилцааны ёс зүйн талаар ойлголт авч, гэр бүлийн хүчирхийлэл гэж юуг хэлдэг, хэрхэн хаана үйлдэгддэг, яагаад далд хэлбэрт оршдог, хэдэн төрөл зүйл байдаг, тус гэмт хэргийн хүчин зүйл, суурь шалтгаан, хууль зүйн орчин зэрэг маш олон ойлголтыг нэгэн зэрэг авч чадлаа.

Бид мэдлэг дутуу, энэ талын ойлголт үгүйгээс өөрсдөө ч мэдэхгүй гэр бүлдээ, хамт олон дундаа хүчирхийлэгч болсноо анзаардаггүй байна. Тиймээс шинж тэмдэг, зан байдлын онцлог, гаргаж буй үйлдэл зэргээ таних мэдэх дасгал ажиллаж харилцан ярилцав.



## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, ёс зүй сахилга хариуцлагыг чанаржуулах зорилго бүхий “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” сэдэвт хойд бүсийн зөвлөгөөн Орхон аймагт 4 дүгээр сарын 07-08-нд боллоо. Зөвлөгөөнд төрийн улс төр, захиргаа, тусгай, үйлчилгээний албанд ажилладаг төрийн албан хаагчдын төлөөлөл оролцож, нийтлэг асуудлаар зөвлөлдөв.

2023 онд шинээр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай анхдагч хууль, түүний хэрэглээг таниулах сургалтыг бодит кейс дээр ажиллах хэлбэрээр зохион байгуулсан нь лекц сонсохоос илүү үр дүнтэй сургалт болсон. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж нь алдаа гаргах бүрд шийтгэхээ урьтал болгохгүй, ёс зүйн алдаа гаргасан төрийн албан хаагч уучлал гуйдаг жишиг тогтоох нь чухал гэдгийг Ёс зүйн хорооны ажлын албаны дарга Н.Ганбаатар тодотголоо.

Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлгийн үеэр яригдсан сэдвүүдийн нэг нь төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл байлаа. Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор аймагт ажилладаг төрийн албан хаагчид 20 хувийн нэмэгдэл, суманд ажилладаг төрийн албан хаагчид 40 хувийн цалингийн нэмэгдэл олгох шийдвэрийн хэрэгжилт зарим төрийн байгууллагад алаг цоог хэрэгжиж байгааг хэлэлцүүлэгт оролцогчид хөндсөн. Энэ мэт хөдөлмөрийн харилцаатай холбоотой түгээмэл асуудал, зөрчлүүдийг зохицуулахад Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох журмуудын ямар зохицуулалтыг хэрхэн хэрэглэх талаар Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа тайлбарлаж, ойлголтын зөрүүг арилгаснаар эхний өдрийн хэлэлцүүлэг өндөрлөсөн.






Зөвлөгөөний хоёр дахь өдөр Төрийн албаны шинэтгэлд чиглэсэн илтгэл, хэлэлцүүлгүүдээр үргэлжилж, цаашид хууль тогтоомжийг хэрхэн сайжруулах талаар оролцогчдын саналыг сонслоо. Хэлэлцүүлэгт Төрийн албаны зөвлөлийн болон Ёс зүйн хорооны гишүүдээс гадна УИХ-ын гишүүн ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар, УИХ-ын гишүүн Б.Хэрлэн, ЗГХЭГ-ын дэд дарга Б.Батцэцэг нар оролцсон юм. Орон нутгийн төлөөлөгчид төрийн албаны нэр хүндийг өсгөх, ажиллах нөхцлийг сайжруулах, хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж боловсруулах зэрэг тулгамдсан, бодлогын өөрчлөлт, шинэчлэлт, уялдаа холбоо шаардсан олон асуудлыг хөндөн ярилцав.

Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах сургалт 2025.02.07-нд боллоо. Сургалтад төвийн 2 албан хаагч хамрагдлаа.

Авлигатай тэмцэх газрын "Авлигаас урьдчилан сэргийлэх нь анхаарах асуудал" сэдэвт цахим сургалт 6 сарын 03-ны өдрийн 10:00 цагт зохион байгуулагдав. Сургалтад төвийн 4 албан хаагч хамрагдав.



Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх цахим сургалтыг ЦУОШГ, АТГ-аас 2025.11.20-нд зохион байгуулж төвийн 4 албан хаагч хамрагдлаа.



Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Авлигатай тэмцэх 5Ш ажиллагаа"-ны ШИЛ ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтийн хяналтыг бий болгох shilen.gov.mn сайтад мэдээлэл байршуулах сургалт 2025 оны 06 сарын 10-нд боллоо. Сургалтад төвийн 2 албан хаагч хамрагдав.

### АМ ЮУГААР ХАЛЬГИНА, АМЬДРАЛ ТҮҮГЭЭР БЯЛХАНА

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хамт олон "ЗАЛУУЧУУДЫН САРЫН АЯН"-ы хүрээнд зохион байгуулж буй "ГЭР БҮЛИЙН ҮНЭ ЦЭН" сэдэвт сургалтад хамрагдлаа. Сургалтыг Харилцааны сэтгэл зүйн доктор Н.Алтанцоож багш удирдан чиглүүлэв.

БИ биш БИД дээр амьдрал тогтдог бөгөөд хамт олноо ойлгож хүлээн зөвшөөрч эерэгээр харж сурах нь чухал болохыг багш маань онцолсон юм.

Хүн бүр нэг хэвд цутгасан мэт адилхан байх албагүй гагцхүү ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрч, давуу тал болгох нь ухаан юм. Хамт олон дунд ч улаан, шар, цэнхэр, ногоон гэх 4 төрлийн хүн зонхилдог байна. Төрөл бүрийн сэтгэхүй, онцлогтой хүмүүс аливааг олон өнцгөөр харж, ажлын бүтээмж нэмэгдэх давуу байдлыг бий болгодог талаар харилцан ярилцлаа.



### ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБА ТӨЛӨВШҮҮЛЬЕ

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хамт олон 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Авлигын эсрэг хууль"-ийн сургалтад хамрагдлаа.



Сургалтыг Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын “Хууль эрх зүйн хэлтэс”-ийн Эрх зүйн хөтөч Г.Ганчимэг удирдан чиглүүлж, хуулийг хэрхэн ухаж ойлгох талаар болон онцлох чухал зүйл заалтууд, анхаарвал зохих асуудлын хамт тайлбарлаж өгөв.

Тус сургалт нь төрийн албан хаагчдын хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх, хариуцлагатай, шударга төрийн алба төлөвшүүлэх зорилготой юм.

### 3. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв фэйсбүүк пэйж хуудсаар болон <https://orkhon.namem.gov.mn/> сайтаар дамжуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн зүйл заалтуудыг олон нийтэд сурталчлах, төвийн албан хаагчдад таниулах ажлыг хийдэг. Тухайлбал, анхаарч ажил албан тушаалдаа өдөр тутамдаа хэрэглэхэд нь ойртуулж байгууллагын зарим байршилд, нүдэнд тусах газар хэвлэн байршуулсан.

<p>Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв Stories   Hurd · Монгол · 3h · 🌐</p>	<p>Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв Posted by С. Оюундарь 3h · 🌐</p> <p>ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИАС</p>	<p>Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв Posted by С. Оюундарь May 16 · 🌐</p> <p>ХҮНИЙ ЭМЗЭГ БОЛОН ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭР БУСДЫГ ГУТААХЫГ ХОРИГЛОНО</p>
<p></p> <p><b>8.2.3 Үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох үйлдэл хийх</b></p> <p>ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИАС</p>	<p></p> <p><b>8.2.3 СОЁЛЫН ЯЛГААТАЙ ХЭВ ШИНЖИЙГ ХАРЬЦУУЛАХ, ШҮҮМЖЛЭХ, ЯЛГАВАРТАЙ ХАНДАХ</b></p> <p>ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИАС</p>	<p></p> <p><b>8.2.3 ХҮНИЙ ЭМЗЭГ БОЛОН ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭР БУСДЫГ ГУТААХ</b></p> <p>ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИАС</p>








Төрийн албан хаагчийн хувьд авлига албан тушаалын хэрэг нь ёс зүйн хамгийн том зөрчил төдийгүй гэмт хэрэг юм. Тиймээс болзошгүй аюулаас сэрэмжлүүлэх зорилгоор авлигын эсрэг нэгдэх, олон нийтийг уриалах, сэрэмжлүүлэх байдлаар мэдээлэл түгээж, ШҮГЭЛ ажиллагаанд нэгдэн ажиллаж байна.



## 5. МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ


Ус цаг уур орчны шинжилгээний төв нь Байгаль орчны салбар бөгөөд судалгаа шинжилгээний байгууллага юм. Тэр ч утгаараа олон нийтэд байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах ёс зүйг төлөвшүүлэх үүрэг хүлээн ажилладаг.



Тиймээс албан хаагчид энэ талын мэдлэг мэдээлэл авах сургалт, хэлэлцүүлэг үйл ажиллагаанд байнга хамрагдан олж авсан мэдлэгээ олон нийтэд түгээх, үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжүүлэх замаар мэргэжлийн ёс зүйг дээдлэн ажиллаж байна.

## 6. ОРОН НУТГИЙН БОДЛОГО ШИЙДВЭР

Орхон аймгийн Засаг даргын тамгын газар, ИТХ зэрэг орон нутгийн бодлогын байгууллагаас хэрэгжүүлж буй ёс зүйн заавар зөвлөмж, бодлого шийдвэр, Засаг даргын захирамж, ИТХ-ын тогтоол зэргийг мөрдөх, албан хаагчдад танилцуулах, олон нийтэд түгээх зэргээр хамтран ажиллаж байна.




## 7. ЁС ЗҮЙТЭЙ ГЭР БҮЛ

Төрийн албан хаагчийн ёс зүй гэдэг ажлын байраар хязгаарлагдахгүй. Гэр бүл олон нийтэд гээд хаана ч ёс зүйгээр үлгэр дуурайлалтай байх ёстой. Тэр ч утгаараа гэр бүлийн харилцаанд ч ёс зүйтэй байхыг албан хаагчид, олон нийтэд уриалан ажиллаж байна. Түүнчлэн Орхон аймгийн Засаг даргын санаачлан хэрэгжүүлж буй “Бүх хайраа гэр бүлдээ” аяныг Ус цаг уур орчны шинжилгээний төв дэмжин ажиллаж байгаа юм.



Ёс зүйтэй албан хаагч ёс зүйтэй гэр бүлийг төлөвшүүлж, ёс зүйтэй иргэн хүнийг төрүүлнэ. Тиймээс хүүхэд хүмүүжлийн эерэг аргууд, харилцааны ёс зүй, хүүхдийн эрх зэргийг сурталчлан, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаж байна.





## 8. ЁС ЗҮЙ ХАБЭА



Хөдөлмөрийн аюулгүй байдал нь албан хаагчийн сэтгэл зүйтэй шууд хамааралтай. Тиймээс ажлын байранд ажилдаа бүрэн төвлөрөх, аюул осолгүй ажиллах боломжийг хангах үүднээс албан хаагчдын хоорондын харилцаа хандлага, ёс зүйг эерэг байлгахад анхааран ажиллаж байна. Аймаг орон нутгаас санаачлан явуулж буй сургалт хэлэлцүүлэгт албан хаагчдаа түлхүү хамруулахын зэрэгцээ, дотооддоо сургалт, ярилцлага санал асуулга зэргийг нэвтрүүлэн ажиллаж байна.



## 9. ЯЛГАВАРЛАЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Төрийн албан хаагч нь иргэд олон нийтэд эрх тэгш, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлж, олж авсан хувь хүний нууцтай холбоотой мэдээллээ задруулахгүй байх үүрэгтэй.


Төрийн албан хаагч нь Монгол улсын үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, ёс зүйн дүрэм журмаа ягштал баримтлах ёстой. Тэр ч утгаараа төрийн албан хаагчдад болон олон нийтэд чиглэсэн постер мэдээллийг байгууллагын сошиал хаягаараа дамжуулан түгээн ажиллаж байна.




## 10. БИЕЭ ЗӨВ АВЧ ЯВАХ ЁС ЗҮЙ

Төрийн албан хаагч нь гудамж талбай, нийтийн эзэмшлийн газарт биеэ соёлтой авч явж, үлгэр дуурайлалтай байх ёстой. Улмаар нийгэмд ёс зүйтэй хандлага, соёлтой зөв харилцаа бий болоход нэг алхам ойртох юм.

Хүний хөдөлмөрийг үнэлдэг, хууль дүрмээ баримталдаг, бусдад зөв шаардлага тавьдаг, буруу зүйлээ ухамсарладаг, хариуцлагаа хүлээдэг байдлыг төлөвшүүлэх зорилгоор олон нийтэд уриалга пост нийтлэн ажиллаж байна.





## 11. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ "ACTIVE YOUTH" АЯН


Орхон аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас санаачлан, Засаг даргын тамгын газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, ГБХХГ, Боловсролын газар хамтран төрийн болон ТББ-ын залуучууд, хувийн хэвшил, холбоод, оюутан сурагчдын дунд залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлэх "Active youth" аян зохион байгууллаа.

Энэхүү үйл ажиллагаа нь 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулагдаж буй бөгөөд "Залуучуудын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, санаачилга, идэвх оролцоог дэмжих, эерэг хандлагыг сурталчлах, залуу гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн үнэ цэнийг ойлгуулах сургалт, хорт зуршлаас урьдчилан сэргийлэхэд чиглэж байгаа юм.

Ус цаг уур, орчны шинжилгээний төв "Active youth" аяны хүрээнд байгууллагадаа болон сошиал хаягаараа дамжуулан эерэг хандлага, ёс зүйг сурталчлах, залуу гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн үнэ цэнийг ойлгуулах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явууллаа.

### "ӨГЛӨӨНИЙ ЦАЙГ ӨӨРТӨӨ" АЯН ЗАРЛАЛАА

Уг үйл ажиллагааны хүрээнд гаргасан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагууд "Active Youth" арга хэмжээг зохион байгуулах тухай удирдамжийн дагуу Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс "ӨГЛӨӨНИЙ ЦАЙГ ӨӨРТӨӨ" аян зарлалаа.




Манай хамт олон өглөө бүр нэг албан хаагч нь санаачлан өглөө бүр өөр өглөөний цай ууж байна. Тухайлбал, эхний өдрийн өглөөний цай элгэн тараг, шинэхэн талх, нойтон өрөм байсан бол дараа нь барьсан талх, шинэхэн боорцог, зэрлэг жимс,

айраг, аарц зэргээр үргэлжлэв. Энэхүү аян нь эрүүл амьдралын хэв маягийг дэмжээд зогсохгүй хамт олны уур амьсгалд эерэгээр нөлөөлөв.

### “БАЯРЛАЛАА” ТАЛАРХЛЫН ДАВЛАГАА ҮҮСГЭВ

Ус цаг уур, орчны шинжилгээний төв фэйсбүүк пэйж хуудсаар “Баярлалаа” талархлын давлагаа явуулж, эмч, цагдаа, онцгой байдлын болон тохижилт үйлчилгээний ажилтнуудад талархал илэрхийлэв. Энэ нь олон нийтэд эерэг сэдэл төрүүлэх, мэргэжлээрээ бахархах байдлыг бий болгохыг эрмэлзэв.



### 12. АЛБАН ХААГЧДЫН ЁС ЗҮЙН ҮНЭЛГЭЭ ГАРГАЖ БАЙНА

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн албан хаагчдын ёс зүйг улирал бүр харилцаа, хандлага, хариуцлага, хамт олонч байдал, хувийн зохион байгуулалт гэсэн 5Х үзүүлэлтээр 1-5 оноогоор дүгнэж байна. Дүгнэлтийг албан хаагчид өөр хоорондоо хийдэг бөгөөд хэн нь хэнд, хэрхэн санал өгч дүгнэж байгааг мэдэгдэхгүй байдлаар зохион байгуулж, санал өгсөн хуудсаа тодорхой цэгт хайрцагт хураан авдаг.

Ёс зүйн дэд хорооны гишүүд үнэлгээний хуудсыг албан хаагч бүрийнхээр нэгтгэн авч дүгнэж байгаа болно.

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчдын ёс зүйн үнэлгээний хуудас

2025.08.18


№	Овог нэр	Харицлаа	Хандлага	Хариуцлага	Хамт олонч байдал	Хувийн зохион байгуулалт	Дундаж оноо
1.	С.Отгонбаатар	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	5,8
2.	О.Хандмаа	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	5,8
3.	Б.Ариунзаяа	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4,2
4.	Д.Давааням	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	5,6
5.	Н.Эрдэнэзаа	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4
6.	Ц.Энхтогос	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	5,6
7.	М.Дагий	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4
8.	Т.Урангоо	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4,2
9.	Б.Хасбат	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4,2
10.	У.Хонгорзул	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4,2
11.	Д.Оюунбат	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4
12.	Г.Билгүүн	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4,2
13.	Б.Өлзийжаргал	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	5,8
14.	Б.Солонго	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4
15.	О.Шүрэнцэцэг	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4
16.	Э.Мөнхтува	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4
17.	Ж.Бямбасайхан	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4
18.	Ч.Өнөрсайхан	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4
19.	Б.Оюунжаргал	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4
20.	С.Оюундарь	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	1 2 3 4 5	4

Тус үнэлгээний хуудаст нэр бүхий албан хаагчдыг 1-5 оноогоор дугуйлан дүгнэх бөгөөд


- 1 оноо маш муу
- 2 оноо муу
- 3 оноо дунд
- 4 оноо сайн
- 5 оноо маш сайн гэсэн утгыг агуулах юм.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн албан хаагчдаас авах сэтгэл ханамжийн судалгаа нь байгууллагынхаа дотоод уур амьсгал, ажилтнуудын оролцоо, ажлын үр бүтээмжийг сайжруулахад чухал ач холбогдолтой. Төвийн албан хаагчдаас 2 төрлийн сэтгэл ханамжийн судалгааг google form-оор авсан. Байгууллагын шударга байдлын үнэлгээгээр **удирдлагын зүгээс хэр дэмждэг вэ?** гэдэг асуултанд нийт албан хаагчдын 55 хувь нь маш сайн, 20 хувь нь сайн гэсэн үнэлгээг өгсөн байна. Мөн **байгууллагын үйл ажиллагаа, цалин, төсвийн ил тод байдал** дээр нийт албан хаагчдын 42,9-76,2 хувь нь маш сайн, сайн үнэлгээг өгсөн байна.

4. Байгууллагын үйл ажиллагаа ил тод шударга байна уу?  
21 responses




5. Удирдлагын зүгээс таныг хэр дэмждэг вэ?  
20 responses




Албан хаагчдын 26,3 хувь нь ажлын орчин нөхцөл, аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэх дээр сайн үнэлгээ өгсөн боловч 15,8 хувь нь шаардлага хангахгүй буюу байгууллагын байр нь цаашид ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан учир шинэ байртай болох гэсэн санал өгсөн байна.


2. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж хангалттай байдаг уу?  
20 responses



5. Та шинэ үр чадвар эзэмших, хөгжих боломжтой байдаг уу?  
19 responses



ТАЗ-өөс зохион байгуулж буй 7 хоног бүрийн пүрэв гарагт 7:4:10 сургалтад албан хаагчдыг тогтмол хамруулж хэвшсэн.



Тухайлбал энэ онд

- Төрийн албаны зөвлөлөөс хяналт, шалгалтын хүрээнд илэрч байгаа зөрчил, дутагдал, эрсдэл, анхаарах асуудлаар мэдээлэл өгөх,
- Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ,
- Монгол бичгийг дижитал орчинд эзэмших,
- Төрийн албаны зөвлөлөөс хяналт, шалгалтын хүрээнд илэрч байгаа зөрчил, дутагдал, эрсдэл, анхаарах асуудлаар мэдээлэл өгөх,
- Ёс зүйн дэд хорооны ажиллах журамын танилцуулга,
- Үндэсний статистикийн хорооноос ДАН системийг зөв ашиглах заавар болон тооллогын мэдээлэл цуглуулах аргачлал,
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх тогтолцоо, хяналтын тухай хуулийн хэрэгжилт, хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг, түүний үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх зэрэг 9 сургалтад давхардсан тоогоор 32 албан хаагч хамрагдсан

Байгууллагаас төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах, авлига албан тушаал хэрэгт холбогдохгүй байх, дүрэм журмаа мөрдөх, тэгш шударга хүртээмжтэй ажиллах чиглэлээр олон хөтөлбөр, сургалт үйл ажиллагаанд хамрагдсан. Албан хаагчид байгууллагын бусад ажилтнуудад мэдлэг мэдээлэл түгээн ажиллав. Байгууллагаас төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах, тэгш шударга хүртээмжтэй ажиллах, эрсдэлээс сэргийлэх, дутагдлын хажуугаар дүүгай өнгөрөхгүй байх чиглэлээр, хамтарсан сургалт мэдээлэл түгээн ажиллав. Жилийн эцсийн байдлаар “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” зөрчсөн албан хаагч байхгүй. Ажлын байранд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэсэн, эсвэл хэрэглэсэн үедээ ажилдаа ирсэн ажилтан байхгүй. Ёс зүйн дэд хороонд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, албан хаагчтай холбоотой санал гомдол ирээгүй бүртгэгдээгүй байна.

Тайлан гаргасан: Ёс зүйн дэд хорооны дарга О.Хандмаа